

УЛСЫН ШАЛГАЛТ - 2025

НИЙГЭМ СУДЛАЛ

XII АНГИ

А хувилбар

Аймаг/дүүрэг:

Сум:.....

Сургууль:

Анги:..... бүлэг:.....

Овог:

Нэр:

САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 80 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

Амжилт хүсье.

НИЙГЭМ СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН 12 ДУГААР АНГИЙН УЛСЫН ШАЛГАЛТЫН СЭДЭВ

А ХУВИЛБАР 80 МИНУТ

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг хэрхэн нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Нийгэмшилтийн бүрдэл B. Нийгэмшилтийн агент C. Нийгэмшилтийн объект
D. Нийгэмшилтийн субъект E. Нийгэмшилтийн нөөц

2. Эдийн засгийн институтын үүрэгт хамаарах ойлголтуудыг сонгоно уу. /2 оноо/

1. Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах 2. Нийгмийн эв нэгдлийг тогтоох
3. Бүлэг болон нийгмийг зохицуулах 4. Боловсон хүчнийг бэлтгэх
5. Эдийн засгийг тогтвортой байлгах 6. Татварын хэмжээг бууруулах

- A. 1, 2, 4 B. 1, 3, 5 C. 1, 5, 6 D. 2, 5, 6 E. 2, 4, 5

3. гэдэг нь ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл юм. /1 оноо/

- A. Нийгмийн нийтлэг B. Нийгмийн давхраа C. Нийгмийн ялгарал
D. Нийгмийн давхраажилт E. Тэгш бус байдал

4. Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс Янки хотын нийгмийн давхраажилтыг судалсан судлаач Л.Уорнерын жишээ загвар аль нь вэ? /1 оноо/

- A. Ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтэний байр суурь илүү өндрөөр үнэлэгдэнэ.
B. Байгууллагад хувь хүмүүс материаллаг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх, чөлөөт цаг ихтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна.
C. Их хэмжээний баялагийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүд хүндэтгэдэг.
D. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзнээс дээд ангид оруулж судална.
E. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

5. 1850 он хүртэлх Америкийн өмнөд, хэсэгт түгээмэл байсан гэж үздэг, орчин үед далд хэлбэрээр оршин байгаа давхраажилтын хэв маяг аль нь вэ? /1 оноо/

- A. Анги бүлэг B. Язгуур угсаа C. Каст D. Нээлттэй нийгэм E. Боолчлол

6. Нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг зөв харгалзуулсан нь аль вэ? /2 оноо/

a	Соёл, технологи	1	Нийгмийн бодит нөхцөл хийгээд түүнийг ямар байх ёстойн талаарх хүлээлт, стандарт хоорондын зөрөөнөөс олон нийтийн дургүйцэл бий болдог.
b	Дайн, улс төрийн мөргөлдөөн	2	Хүн төрөлхтний түүхийн туршид цэргийн хүчин баялгийг олж авах хүчин зүйл болж байсны хувьд эдийн засгийн өөрчлөлтөд ихээхэн нөлөөлжээ.
c	Нийгмийн хөдөлгөөн	3	Дулаан, цахилгааны эрчим хүчийг ашиглах технологи нэвтэрсэн нь аж үйлдвэржилтийг эрчимжүүлсэн.

- A. a3b1c2 B. a1b2c3 C. a1b3c2 D. a2b3c1 E. a3b2c1

7. Давхраажилтын дараах хэмжигдэхүүнээс эрх мэдлийн төрөлд аль нь хамаарах вэ? /1 оноо/

- A. Үл хөдлөх хөрөнгө эзэмших B. Онцгой авьяас чадвар
C. Язгууртан угсаатан байх D. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэнэ
E. Бусдад нөлөөлөх, дагуулах

8. Дараах ойлголтуудаас чанарын судалгаанд аль нь хамаарах вэ? /2 оноо/

1. Цөөн тооны хувьсагч хоорондын хамаарлыг шалгахад анхаарна.
2. Судлагчдын яриа, үйлдлээс хамаарсан олон тооны хувьсагч байна.
3. Мэдээлэл цуглуулах үйл явц нэг ижил горимоор явагдана.
4. Хэмжилт мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ.
5. Математик статистикийн аргуудаар шинжилгээ хийнэ.

A. 1, 4 B. 2, 4 C. 3, 5 D. 4, 5 E. 2, 3

9. Нийгмийн өөрчлөлтийн үе шатуудыг зөв харгалзуулсан нь аль вэ? /4 оноо/

a) Ан агнуурын нийгэм b) Цэцэрлэг, аж ахуйн нийгэм c) Газар тариалангийн нийгэм d) Аж үйлдвэржсэн нийгэм e) Аж үйлдвэржилтийн дараах нийгэм	1	Даяаршил, мэдээлэл технологийн хурдац маш өндөр түвшинд явагдана.
	2	Ураг төрлийн холбоонд суурилсан олон төрлийн овгуудаас тогтох нийгэм
	3	Улс төрийн бүтэц үгүй, овгийн байгуулал бүхий нийгэм
	4	Хүн амьтны булчингийн хүчийг халж, дулаан, цахилгаан, атомын хүчийг ашигласан үе
	5	Төр үүсэж, бичиг үсэг хэрэглэх болж, мөнгөн гүйлгээ ашиглах болсон үе
	6	Хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн нийгэм

A. a3b6c2d4e1 B. a6b2c3d5e4 C. a4b3c2d1e6 D. a3b5c1d4e2 E. a3b2c5d4e1

10. “Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж, өвлөх үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэнэ” гэж дараах эрдэмтдээс хэн нь үзсэн бэ? /1 оноо/

A. Р.Бенедикт B. Э.Тайлор C. Ж.Мёрдок D. А.Гидденс E. Э.Кассирер

11. Соёлыг бүрдүүлэгч элементийг холбогдох ойлголттой нь зөв илэрхийлсэнхариулт аль нь вэ? /1 оноо/

- A. Үнэлэмж - шударга ёс, загалмай
- B. Мэдлэг – домог, хуримын бөгж
- C. Хэл – дохио зангаа, шашин
- D. Бэлгэ тэмдэг – төрийн дуулал, хөшөө
- E. Хэм хэмжээ – дүрэм, журам, шинжлэх ухаан

12. Соёлын ангилалыг шалгууртай нь тохирох утгаар нь зөв харгалзуулсан нь аль вэ? /2 оноо/

a	Хэн бүтээсэн, ямар түвшний соёл вэ	1	Олон улсын соёл, улс үндэсний соёл
b	Соёлын түвшин	2	Ардын соёл, нийтийн соёл, сонгодог соёл
c	Соёлын илрэх байдлаар	3	Эдийн соёл, оюуны соёл

A. a2b1c3 B. a1b2c3 C. a1b3c2 D. a2b3c1 E. a3b2c1

13. Доорх соёлын хэв маягийг түүхэн дарааллаар нь байршуулна уу. /2 оноо/

1. Эртний 2. Хүй нэгдлийн 3. Дундад зууны 4. Сэргэн мандалтын 5. Шинэ үеийн 6. Орчин үеийн
- A. 1-3-2-4-6-5 B. 1-3-2-4-5-6 C. 2-1-3-4-5-6 D. 2-1-3-4-6-5 E. 1-3-2-5-4-6

14. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд үл хамаарах салбарыг тэмдэглээрэй. /1 оноо/

- A. Дизайн, дүрслэх урлаг
- B. Мэдээллийн технологи
- C. Соёлын өв
- D. Тайзны уран бүтээл
- E. Кино урлаг

15. Дараах бүдүүвчийг ажиглаад соёлын харилцан үйлчлэлийн хэлбэрийг гүйцээгээрэй. /1 оноо/

Соёлын харилцан үйлчлэл	
	Өөрийн орны соёлыг танилцуулах, бусад орнуудын соёлтой танилцах, солилцох, хамтран ажиллах үйл явц юм.
	Бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц юм.

- A. Соёлыг хуулбарлан дуурайх
- B. Соёлын тулгалт
- C. Соёлын адилсал
- D. Соёлын солилцоо
- E. Соёлын орон зай

16. Соёлын шалгуур үзүүлэлтийн дагуу “Хүмүүсийн сонголт хийх боломж өөр байж болно” гэсэн үзүүлэлтэд тохирох хариултыг олно уу? /1 оноо/

- A. Нэг хэв загварын ба олон хэв загварын соёл
 B. Эртний соёл, Дундад зууны соёл
 C. Олон улсын соёл ба монголчуудын соёл, баруун монголын соёл
 D. Ёс суртахууны соёл, шашны соёл, дугуй сонирхогчдын соёл

17. Соёлын эрх чөлөөний талаарх өгөгдлүүдийг зөв харгалзуулсан нь аль вэ? / 2 оноо/

a	Соёлын эрх чөлөө	1	Угсаатны ялгаатай бүлгүүд болон нутгийн уугуул иргэдийн соёлыг оролцуулан бүх соёлыг ижил тэгш үнэлж хүндэтгэх
b	Соёлын эрх чөлөөний суурь зарчим	2	Амьдралын хэв маягийг үгүйсгэх.
c	Соёлын эрх чөлөөг зөрчих хандлага	3	Бүх хүмүүс эх хэлээрээ ярьж, өөрийн шашныг шүтэж, өөрийн соёлыг бүтээн туурвих бололцоог эдлэх эрх

- A. a3b1c2 B. a1b2c3 C. a1b3c2 D. a2b3c1 E. a3b2c1

18. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /4 оноо/

a) Соёлын үйлдвэрлэл b) Соёлын даяаршил c) Соёлын тулгалт d) Соёлын хуулбарлан дуурайх	1. Нэг хэсэг хүн амын соёлын амьдрал нөгөө хэсгийнхтэй адилсан, өмнөх соёлоосоо илүүд үзэх үр дүн юм.
	2. Бүтээсэн бүхнийг устгаж, хүнийг тэр зүйлээ дахин бүтээхгүй болтол нь айлган сүрдүүлэх үйл явц
	3. Оюуны өмчөөр хамгаалагдсан, соёлын агуулга бүхий бараа, бүтээл үйлдвэрлэх, тэдгээрийн хуваарилалт нийлүүлэлтийн тогтолцоо.
	4. Уламжлалт ёс заншлыг байгаагаар нь мухар сохроор ёсчлон дагах биш, харин хүний сонголт хийх бололцоог өргөжүүлэх
	5. Соёлын үнэлэмжүүдийн харилцан нөлөөллөөр бий болж байдаг орчин ба улс үндэстэн, хүмүүсийн хамтын мэдрэмж

- A. a3b4c2d1 B. a3b5c2d1 C. a2b3c5d1 D. a5b4c1d3 E. a4b1c3d5

19. 2020 онд COVID-19 цар тахлын үеэр АНУ-д ажилгүйдлийн түвшин 14.7%-д хүрч, 20 сая гаруй хүн ажлаасаа халагдсан. Энэ үзэгдэл аль ажилгүйдлийн төрөлд хамаарах вэ? /1 оноо/

- A. Улирлын ажилгүйдэл B. Бүтцийн ажилгүйдэл
 C. Зөрөөний ажилгүйдэл D. Мөчлөгийн ажилгүйдэл

20. Мөнгө яагаад хуримтлалын хэрэгсэл болдог вэ? /1 оноо/

- A. Бүтээгдэхүүн, үйлчилгээ хэр үнэ цэнтэй болохыг хэмжих хэрэгсэл учир
 B. Мөнгөөр аливаа бүтээгдэхүүнийг шууд худалдан авах боломжтой учир
 C. Өөрийн баялгийг мөнгө байдлаар хадгалах нь илүү найдвартай учир
 D. Мөнгийг бусад субъектэд зээлдүүлж, хүүтэй буцаан авч болох учир

21. 2023 онд Монгол Улсад инфляци 12% давж, хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ огцом өссөн. Үүний улмаас Монгол банк бодлогын хүүг 13% болгон нэмэгдүүлсэн. Монгол банк бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь ямар төрлийн бодлогын хэрэгжилт вэ? /1 оноо/

- A. Төрийн сангийн бодлого B. Гадаад худалдааны бодлого
 C. Мөнгөний бодлого D. Хэрэглээний бодлого

22. Эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхийн тулд нийт эрэлтийг нэмэгдүүлнэ. Тэгвэл нийт эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд ямар арга механизм ашиглах вэ? /1 оноо/

- A. Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. B. Улсын төсвийн зардлыг бууруулна.
 C. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлнэ. D. Татварын хувь хэмжээг бууруулна

23. 2023 оны 4-р улиралд Монгол Улсын ажилгүйдлийн түвшин 3.9% байсан бол ажиллах хүчний тоо 1,200,000 хүн байжээ. Ажилгүйчүүдийн тоог тооцоолон гаргана уу. /2 оноо/

- A. 46,800 хүн B. 48,000 хүн C. 50,000 хүн D. 52,000 хүн

24. Нэгж хувьцааны үнэ 2024 оны эхэнд 1,200₮ байсан бол жилийн сүүлчээр 1,560₮ болж өссөн байна. Хувьцаа хэдэн хувиар өссөнийг тооцоолон зөв хариултыг сонгоно уу? /2 оноо/

- A. Хувьцааны үнэ 20% өссөн, зах зээл уналтад орсон
 B. Хувьцааны үнэ 30% өссөн, хөрөнгө оруулагчдын итгэл сайжирсан

- C. Хувьцааны үнэ 15% буурсан, эрэлт буурсан
D. Хувьцааны үнэ 10% өссөн, тогтмол өсөлттэй

25. Гадаад худалдааны бодлогод хамаарах нөхцөлийг зөв харгалзуулсан нь аль нь вэ? /2 оноо/

1	Засгийн газар дотоодын үйлдвэрлэлийг хамгаалахын тулд импортын татвар нэмэгдүүлэв.	A	Валютын зохицуулалтын бодлого
2	Экспортлогчдод татаас олгож, гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг нь дэмжив.	B	Экспортыг дэмжих бодлого
3	Импортын бараанд хязгаарлалт тавихгүй, зах зээлд нээлттэй ханддаг.	C	Хамгаалалтын бодлого
4	Ханшийн уналтаас сэргийлэх зорилгоор валютын зохицуулалт хийв.	D	Чөлөөт худалдааны бодлого

A. 1C 2B 3D 4A

B. 1C 2B 3A 4D

C. 1B 2C 3D4A

D. 1A2B3C4D

Дараах тохиолдлыг уншаад 26-28 хүртэлх даалгаврыг гүйцэтгээрэй.

Иргэн А нь рестораны эзэн бөгөөд тогоочийн туслах ажилтан авах зорилгоор зар оруулжээ. Тухайн зарыг сайн дураар даатгуулагч (12 сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн) иргэн Б (28 настай) хараад иргэн А буюу ажил олгогчтой уулзаж, тогоочийн туслах ажилтнаар ажиллах болсон. Харин ажил олгогч А нь ажилтан Б-тай хөдөлмөрийн гэрээ байгуулалгүйгээр ажлын чиг үүрэг өгч ажил эхлүүлсэн байна.

26. Ажил олгогч А ажилтан Б-с ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болох уу? /1 оноо/

- A. Ажил олгогч А үндсэн хуулийн 16-р зүйлийг үндэслэн ажилтан Б-г тогоочийн туслах ажилтнаар ажиллуулж болно.
B. Иргэн Б тогоочийн туслах ажилтнаар ажилд орсон тул хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлагагүй тул, ажил үүргээ гүйцэтгэж болно.
C. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй бол ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болохгүй.
D. Ажил олгогч А хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийг үндэслэн ажилтан Б-г тогоочийн туслах ажилтнаар ажиллуулж болно.
E. Хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ч гэсэн ажилтнаас ажил үүрэг гүйцэтгэхийг шаардаж болно.

27. Хэрвээ А сахилгын зөрчил гаргасан бол хэдэн сарын дотор шийтгэл ноогдуулах ёстой вэ? /3 оноо/

- A. Зөрчил гарснаас хойш 9 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 4 сарын дотор
B. Зөрчил гарснаас хойш 7 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 2 сарын дотор
C. Зөрчил гарснаас хойш 8 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 3 сарын дотор
D. Зөрчил гарснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор
E. Зөрчил гарснаас хойш 1 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 5 сарын дотор

28. Хэрвээ иргэн Б жирэмсэн байсан бол жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг цалингийн хэдэн хувиар тооцон нийгмийн даатгалын сангаас авах ёстой вэ? /3 оноо/

- A. 9 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
B. 6 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
C. 12 сарын цалингийн дунджийг 100 хувиар тооцно.
D. 6 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.
E. 12 сарын цалингийн дунджийг 70 хувиар тооцно.

29. Баянгол дүүргийн засаг дарга 2017 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 59 дүгээр захирамжаар иргэн Б-д, мөн оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 274 дүгээр захирамжаар иргэн Г-д газар олгохдоо иргэн Б-ийн нэр дээр байдаг “Очир” дэлгүүрийн газартай давхцал бүхий хэсгийг давхардуулан олгосон байна. Дээрх тохиолдолд иргэн Б эрх зөрчигдсөн гэж үзэн дээд шатны байгууллагад гомдол гаргажээ. Баянгол дүүргийн засаг дарга аль субъектэд хамаарах вэ? /1 оноо/

- A. Хариуцагч
B. Хуулийн этгээд
C. Гомдол гаргаж буй иргэн
D. Бусад оролцогч
E. Гуравдагч этгээд

30. Аль нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? /1 оноо/

- A. Зохиогчийн эрхийг зөрчиж байгаа бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, улсын хилээр нэвтрүүлсний улмаас зохиогчид их хэмжээний хохирол учирсан бол
- B. Иргэн Э нь өөрийн эзэмшлийн PRUIS-30 маркийн автомашиныг түрээсийн гэрээгээр Б-д шилжүүлэв. Гэтэл 1 сарын дараа Б нь автомашиныг осолд оруулж дахиж унах аргагүй болгожээ. Тэрээр өөрийн өмч хөрөнгөд халдсан гэж үзээд
- C. Иргэн Ц нь өөрийг нь ямар ч үндэслэлгүйгээр төрийн албанаас халсан гэж үзээд
- D. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар өөрийн мэдэлд шилжүүлсэн авсан нь тогтоогдвол
- E. Төр нь хүний тодорхой эрхийг хүлээн зөвшөөрөөгүй бол

31. Иргэн А нь малаа бэлчээрт гаргахын тулд Б-тэй зөвшилцөн түүний газрыг хязгаартай ашиглах гэрээ байгуулж хоёр тал тохиролцсон. Хэсэг хугацааны дараа гэрээнд тусгагдсан зүйлүүд зөрчигдөж, иргэн Б ашиг орлогоо алдаж, өмч хөрөнгөнд нь хохирол учирсан. Энэ тохиолдолд иргэн Б ямар шатны шүүхэд нэхэмжлэл гаргах вэ? /1 оноо/

- A. Аймаг нийслэлийн шүүх
- B. Иргэний хэргийн дунд шатны шүүх
- C. Захиргааны хэргийн анхан шатны шүүх
- D. Захиргааны хэргийн дунд шатны шүүх
- E. Иргэний хэргийн анхан шатны шүүх

32. Хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдээс илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/

- A. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ
- B. Ажлын байрны буюу албан тушаалын нэр
- C. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг
- D. Нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал
- E. Хөдөлмөрийн нөхцөл

33. Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэ нь ардчиллын аль зарчим вэ? /1 оноо/

- A. Хууль дээдлэх зарчим
- B. Цөөнхийг хүндэтгэх зарчим
- C. Нээлттэй байх зарчим
- D. Шударга байх зарчим
- E. Зөвшилцлийн зарчим

34. Ардчиллыг олон янзаар тодорхойлдог. Үл хамаарах нь аль вэ? /1 оноо/

- A. Ард түмнээс олгосон эрх мэдлийн хүрээнд ажиллах төрийн хэлбэр
- B. Дээд эрх мэдлийг ард түмэнтэй эдлэх эрхийн тогтолцоо
- C. Бүх эрх мэдлийг ард түмэнтэй эдлэх үүргийн тогтолцоо
- D. Ард түмний засаглал
- E. Бүгд хамаарна

35. Энэхүү баримт нь сонгуулийн ямар тогтолцооны онцлогийг илүү оновчтой харуулж байна вэ? “2016 оны УИХ-ын сонгуульд МАН нийт сонгогчдын 45,69 хувийн санал авсан ч парламентын суудлын 85,5 хувь буюу 65 суудлыг авч байсан бол бусад нам эвслүүд нийт сонгогчдын 54,31 хувийн санал авсан хэдий ч парламентад 11 суудал авч байжээ”. /2 оноо/

- A. Мажоритари тогтолцооны
- B. Пропорциональ тогтолцооны
- C. Холимог тогтолцооны
- D. Мажоритари харьцангуй олонхын тогтолцооны
- E. Мажоритари системийн энгийн олонхын тогтолцооны

36. Зарим улс орны сонирхлын бүлэг парламенттай харилцах харьцааг зөв харгалзуулсан нь аль вэ ? /2 оноо/

a	Герман	1	Сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг
b	АНУ	2	Дэд хороо болоод ажлын хэсэг нь сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрдөг
c	Их Британи	3	Сонирхлын бүлгүүд нь мужийн засаг захиргаатай зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа нөхцөлд уг асуудлаа нийт улсын хэмжээнд дэлгэн тавьж хуулиар шийдвэрлүүлнэ
d	ОХУ	4	Сонирхлын бүлгүүд нь гүйцэтгэх засаглалтай холбогддогийнхоо хувьд яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцдаг

A. a3b1c2d4

B. a4b3c2d1

C. a2b3c4d1

D. a3b4c1d2

E. a4b1c2d3

37. Сонгогдох эрхийн шалгуурт хамааралгүй зүйл аль нь вэ? /1 оноо/

A. Гадаадад дээд боловсрол эзэмшсэн байх

B. Сүүлийн 5 жил эх орондоо тогтвор суурьшилтай амьдарсан

C. УИХ-ын гишүүнд нэр дэвшихэд 25 нас хүрсэн байх

D. Ерөнхийлөгчид нэр дэвшихэд 45 нас хүрсэн байх

E. Эрх зүйн чадамж бүхий иргэн байх

38. Төрийн салшгүй үндсэн 3 гол шинжийг гүйцээж бичээрэй. /1 оноо/

1. Нийтлэг шинж

2. Нутаг дэвсгэр

3.

A. Соёлын хараат бус байдал

B. Үзэл суртал

C. Төрийн бэлгэдэл

D. Хүн ам

E. Эдийн засгийн бие даасан байдал

39. Улс төрийн намын нийгэмд гүйцэтгэх үүрэгт аль аль нь хамаарах вэ? /2 оноо/

Хэсэг	А	Б
1-р хэсэг	Иргэдийн оролцоог хангах	Төр, эдийн засаг, гэр бүлээс ангид гэр бүлээс ангид оршино
2-р хэсэг	Бодлогын хэрэгжилтээ тайлагнах, хариуцлага хүлээх	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд иргэдийн боломжийг хязгаарлах

A. 1-р хэсэг-А, 1-р хэсэг-Б

B. 1-р хэсэг-А, 2-р хэсэг-Б

C. 1-р хэсэг-А, 2-р хэсэг-А

D. 1-р хэсэг-Б, 2-р хэсэг-Б

E. 1-р хэсэг-Б, 2-р хэсэг-А

40. “ХҮ Далай лам, Билл Гейтс” зэрэг субъектүүд улс бус оролцогчдын аль ангилалд хамаарах вэ? /1 оноо/

A. Олон улсын байгууллага

B. Нөлөө бүхий хүн

C. Террорист, зэвсэгт бүлэглэлүүд

D. Олон улсын төрийн бус байгууллага

E. Шашны байгууллага

41. Улс бус оролцогчдын хоорондын уялдаа холбоог илтгэх жишээ аль нь вэ? /1 оноо/

A. Далай лам НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд суух

B. Билл Гейтс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хандив өгөх

C. НАТО гишүүн орнуудад тусламж үзүүлэх

D. Ватикан зэвсэгт хүчин байгуулсан

42. Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилтыг олно уу? /1 оноо/

A. ОХУ, БНХАУ-тай найрсаг, сайн хөршийн хамтын ажиллагааг хөгжүүлэх

B. Ази, Номхон далайн улс орнуудтай харилцах

C. АНУ ба өрнөдийн хөгжингүй орнуудтай харилцах

D. Посткоммунист орнуудтай харилцах

E. Дэлхийн бүх орнуудтай харилцаж хамтын ажиллагаа өрнүүлэх

43. Улс бус оролцогчдын олон улсын харилцаанд оролцох үндсэн шалтгаан аль нь вэ? /1 оноо/

A. Улс төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэх

B. Гадаад худалдааг дангаараа зохицуулах

C. Глобал асуудалд нөлөөлөх, шийдэлд оролцох

D. Улсын хууль тогтоомжийг батлах

44. Монгол Улс “Гуравдагч хөршийн бодлого” баримтлахын гол зорилго юу вэ? /2 оноо/

A. Хөрш орнуудтай харилцаагаа таслах

B. Гуравдагч хөршүүдээс эдийн засгийн, улс төрийн дэмжлэг авах

C. Цэргийн эвсэл байгуулах

D. Гадаад бодлогыг төвлөрүүлэх

45. Монгол Улсын төр засаг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд хүний эрхийн талаарх тайлангаа тавьжээ. Уг тайлан нь Монголд хүний эрхийн байдал хэрхэн байгааг дэлхийн олон улсад танилцуулжээ. Энэ тохиолдолд Монгол Улс олон улсын харилцааны ямар хэлбэрээр оролцогч болж байна вэ? /2 оноо/

A. Боловсролын байгууллагаар дамжин

B. Төрийн гадаад бодлогоор дамжин

C. Иргэний санаачилгаар

D. Хувийн компанийн зүгээс

46. Монголын хүүхдийн төлөө “Өнөр бүл” төв нь ЮНИСЕФ-ийн санхүүжилттэй хүүхэд хамгааллын төсөл хэрэгжүүлж байна. Энэ тохиолдолд ямар дүгнэлтэд хүргэж болох вэ? /2 оноо/

A. ТББ-ууд зөвхөн дотоодын асуудлаар ажилладаг

B. Монголын ТББ-ууд олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, харилцаанд оролцож чаддаг

- С. ЮНИСЕФ зөвхөн төртэй хамтран ажилладаг
 D. Хүүхдийн асуудал бол зөвхөн дотоод асуудал

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгөгдлийг харгалзах утгатай нь зөв харгалзуулаарай. /5 оноо/

a	Сахилгын зөрчил	1	Хүний эрх, эрх чөлөө
b	Сахилгын зөрчил оногдох шийтгэл	2	Зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс 1 сарын дотор ногдуулах ёстой.
c	Сахилгын шийтгэлийг	3	Сануулах, үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, ажлаас халах
d	Иргэн	4	Шийдвэр, үйл ажиллагаа
e	Захиргаа	5	Ажил шалтгаангүйгээр таслах, ажлаа зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас зохих этгээдээс гомдол гаргах, зөрчил нь шалгалтаар тогтоогдох, ажлын байранд согтуурах зэрэг тохиолдол байна.

2.2. Улс төрийн системийн ойлголтуудыг тохирох өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу. /5 оноо/

a	Оролтод хамаарах шаардлага	1	Төрийн бодлогын тодорхой илрэл болсон төрийн хууль тогтоомж, мэдээлэл, сурталчилгаа гэх мэт
b	Оролцооны дэмжлэг	2	Татвар төлөх, төрийн болон цэргийн алба хаших, хууль дүрмийг дагаж мөрдөх, төрийн албан ёсны мэдээлэл, бэлгэдлийг хүндэтгэх
c	Бодит дэмжлэг	3	Улс төрийн системийн дотроос эсвэл, түүнийг хүрээлэн байгаа экологи, эдийн засаг, соёл зэрэг янз бүрийн системүүдээс гарч буй тулгалтууд
d	Шийдвэр, үйлдэл	4	Аль нэг нам нэр дэвшигчийн төлөө санал өгөх
e	Эргэх холбоо	5	Нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдгээрээ онцлогтой

2.3. Өгөгдлийг харгалзах утгатай нь зөв харгалзуулаарай. /5 оноо/

a	Реалист онол	1	ОУХ-ны үндсэн тоглогч бүрэн эрхт улс дангаар биш түүнээс гадна ОУБ, томоохон компаниуд, үндэсний болон бусад нийгэмлэг
b	Либерал онол	2	ОУХ-ны тоглогчид нь бүрэн эрхт улс, тэдгээрийн холбоо, эвсэл байна.
c	Марксист онол	3	ОУХ-ны тоглогчид нь зөвхөн үндэсний бүрэн эрхт улсууд байдаг.
d	Неомарксист онол	4	ОУХ нь нийгмийн тодорхой анги бүлэглэлүүдийн харилцааны үр дүн юм.
e	Неореалист онол	5	ОУХ-ны үндсэн тоглогчид нь нийгмийн ангиуд байна .

2.4 Дараах тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж гадаад худалдааны тэнцэл, нийт эргэлтийг тооцоолж олно уу. /5 оноо/

Монгол улсын гадаад худалдаа, сая ам.долл.				
№	Үзүүлэлт	2021	2022	2023
1	Нийт экспорт	4896.5	4952.9	5842.8
2	Нийт импорт	4547.3	5599.3	4998.7
3	Гадаад худалдааны тэнцэл ашиг / алдагдал			
4	Нийт эргэлт			

_____оОо_____